



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/28/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр
орлон гүйцэтгэгч : Г.Заяа
Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК
Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг
Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	14
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	14
4.2.1 Залруулсан алдаа.....	14
4.2.2 Төлбөрийн акт.....	15
4.2.3 Албан шаардлага	15
4.2.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1. Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

Ауд. 02. 22 № 1302/145

танай _____ -ны № _____ -т

ТҮДЭВТЭЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.БАТМӨНХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

51.5 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг бүрдүүлэлгүйгээр ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, 2.8 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр хувь хүний дансанд шилжүүлсэн зэрэг зөрчил нь (Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1; 13.5; 13.6; 13.7; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-д тусгагдсан заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

010025401

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,751.29</u>	<u>19,215.13</u>
33	АВЛАГА	1,184.16	-
335	Бусад авлага	1,184.16	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,184.16	-
35	БАРАА МАТЕРИАЛ	12,567.13	19,215.13
354	Хангамжийн материал	10,467.13	19,215.13
35410	Бичиг хэргийн материал	525.00	1,550.00
35420	Аж ахуйн материал	205.25	7,948.25
35450	Барилгын засварын материал	20.00	-
35470	Бусад хангамжийн материал	9,716.88	9,716.88
35600	Мал амьтад	2,100.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>424,337.73</u>	<u>397,563.44</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	424,337.73	397,563.44
392	Биет хөрөнгө	421,289.56	395,207.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	349,513.11	349,513.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(95,495.59)	(137,112.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	143,581.35	170,581.35
39204	Хуримтлагдсан элэгдэл	(88,992.06)	(103,006.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,987.08	51,581.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,770.82)	(30,035.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,176.84	16,176.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,833.41)	(12,811.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	200,236.46	217,474.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	(118,673.11)	(128,712.32)
39217	Ном	1,559.70	1,559.70
393	Биет бус хөрөнгө	3,048.17	2,355.76
39301	Програм хангамж	4,524.50	4,524.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,476.33)	(2,168.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>438,089.03</u>	<u>416,778.57</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>438,089.03</u>	<u>416,778.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	438,089.03	416,778.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	507,582.22	507,582.22
51101	Өмч: - төрийн	507,582.22	507,582.22
512	Хуримтлагдсан үр дүн	(283,434.59)	(304,745.04)
51210	Өмнөх үеийн үр дүн	(225,637.19)	(283,434.59)
51220	Тайлант үеийн үр дүн	(57,797.40)	(21,310.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	213,941.40	213,941.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>438,089.03</u>	<u>416,778.57</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	354,258.97	385,876.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,919.84	73,129.01
120	Нийтлэг татварын бус орлого	32,919.84	73,129.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,919.84	73,129.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,581.70	58,890.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,338.14	14,238.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	321,339.13	312,747.30
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	321,339.13	312,747.30
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	321,339.13	312,747.30
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	411,268.22	407,186.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411,268.22	407,186.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	404,906.25	401,569.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,041.46	212,181.89
210101	Үндсэн цалин	220,041.46	212,181.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,235.82	27,034.36
210201	Тэтгэврийн даатгал	15,938.57	20,550.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,466.75	1,086.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839.03	3,109.66
210204	Ажилгүйдлийн даатгал	810.08	207.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,181.38	2,079.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,617.81	25,633.75
210301	Гэрэл, цахилгаан	1,872.38	1,620.85
210302	Түлш, халаалт	22,745.43	24,012.90
2104	Хангамж, бараа материалын зардал	34,374.65	41,885.56
210401	Бичиг хэрэг	2,714.10	2,338.60
210402	Тээвэр, шатахуун	27,778.44	23,774.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,571.20	2,931.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,310.91	12,840.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,228.20	20.00
210604	Урсгал засвар	2,228.20	20.00
2107	Томилолт, зочны зардал	1,416.00	3,161.20
210702	Дотоод албан томилолт	1,416.00	3,161.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,734.04	2,605.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,516.40	1,292.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.00	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74.84	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.00	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	248.40	171.45

210807	Газрын төлбөр	138.30	138.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,258.28	89,047.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,135.00	14,331.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	109.15
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,123.28	74,606.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,361.97	5,616.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	1,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,361.97	4,116.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,361.97	4,116.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(57,009.25)	(21,310.45)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	788.15	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	788.15	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(788.15)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(57,797.40)	(21,310.45)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	507,582.22	213,941.40	(225,637.19)	495,886.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	507,582.22	213,941.40	(225,637.19)	495,886.42
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	(57,797.40)	(57,797.40)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	507,582.22	213,941.40	(283,434.59)	438,089.03
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	507,582.22	213,941.40	(283,434.59)	438,089.03
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	507,582.22	213,941.40	(283,434.59)	438,089.03
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(21,310.45)	(21,310.45)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	507,582.22	213,941.40	(304,745.04)	416,778.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>338,920.83</u>	<u>371,638.01</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,581.70	58,890.71
120	Нийтлэг татварын бус орлого	17,581.70	58,890.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,581.70	58,890.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,581.70	58,890.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	321,339.13	312,747.30
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	321,339.13	312,747.30
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	321,339.13	312,747.30
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>333,235.03</u>	<u>339,228.01</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	333,235.03	339,228.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,873.06	333,611.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	220,041.46	212,181.89
210101	Үндсэн цалин	214,006.12	212,181.89
210105	Гэрээт ажлын хөлс	6,035.34	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,235.82	27,034.36
210201	Тэтгэврийн даатгал	15,938.57	20,550.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,466.75	1,086.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,839.03	3,109.66
210204	Ажилгүйдлийн даатгал	810.08	207.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,181.38	2,079.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,937.81	30,701.50
210301	Гэрэл, цахилгаан	1,872.38	2,768.60
210302	Түлш, халаалт	24,065.43	27,932.90
2104	Хангамж, бараа материалын зардал	30,182.01	22,676.30
210401	Бичиг хэрэг	2,460.60	3,124.15
210402	Тээвэр, шатахуун	26,150.21	16,620.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,571.20	2,931.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,228.20	1,228.20
210604	Урсгал засвар	2,228.20	1,228.20
2107	Томилолт, зочны зардал	1,416.00	3,161.20
210702	Дотоод албан томилолт	1,416.00	3,161.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,154.04	3,309.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,831.40	1,996.71
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.00	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	74.84	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.00	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353.40	171.45

210807	Газрын төлбөр	138.30	138.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,677.73	33,318.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,677.73	32,969.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	348.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,361.97	5,616.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	1,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,361.97	4,116.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,361.97	4,116.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,685.80</u>	<u>32,410.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,685.80	32,410.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,685.80	32,410.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,685.80	32,410.00
223001	Бусад хөрөнгө	4,035.80	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650.00	32,410.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,685.80)</u>	<u>(32,410.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	292,747.30	308,392.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,747.30	308,392.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,747.30	306,892.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,651.60	212,181.89
210101	Үндсэн цалин	201,857.70	212,181.89
210105	Гэрээт ажлын хөлс	6,793.90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,168.00	27,034.36
210201	Тэтгэврийн даатгал	19,821.90	20,550.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,086.50	1,086.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,669.30	3,109.66
210204	Ажилгүйдлийн даатгал	417.30	207.96
210205	Эрүүл мэндийн даатгал	4,173.00	2,079.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,701.50	30,701.50
210301	Гэрэл, цахилгаан	2,768.60	2,768.60
210302	Түлш, халаалт	27,932.90	27,932.90
2104	Хангамж, бараа материалын зардал	16,473.30	16,473.30
210401	Бичиг хэрэг	2,793.00	3,124.15

210402	Тээвэр, шатахуун	10,417.50	10,417.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,262.80	2,931.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,228.20	1,228.20
210604	Урсгал засвар	1,228.20	1,228.20
2107	Томилолт, зочны зардал	3,161.20	3,161.20
210702	Дотоод албан томилолт	3,161.20	3,161.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,560.10	2,698.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200.00	1,386.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232.10	232.10
210803	Даатгалын үйлчилгээ	469.10	469.10
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.70	227.70
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73.80	73.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.40	171.45
210807	Газрын төлбөр	138.30	138.30
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.70	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,803.40	13,413.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500.00	13,064.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303.40	348.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	1,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	292,747.30	308,630.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	292,747.30	308,630.39
122005	Орон нутгийн төсвөөс	292,747.30	308,630.39

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,890.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,890.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,890.7
2104	Хангамж, бараа материалын зардал	6,203.0
210402	Тээвэр, шатахуун	6,203.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	610.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	610.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,077.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,077.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,890.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,890.7
1200	Нийтлэг татварын бус орлого	58,890.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	58,890.7

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 25-ны өдрийн №3/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газар нь төрийн үйлчилгээг иргэдэд хүнд сурталгүй, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх явдал юм. Зорилт, чиг үүргүүд нь төрийн хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь барагдуулж санал хүсэлтийг бодлогын баримт бичгүүдэд тусган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү үйл ажиллагаандаа дагаж мөрддөг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн 312.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 70 хувь буюу 2.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,184.16	-	(1,184.16)
Бараа материал	12,567.13	19,215.13	6,648.00
Үндсэн хөрөнгө	424,337.73	397,563.44	(26,774.29)
Нийт хөрөнгө	438,089.03	416,778.57	(21,310.45)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	438,089.03	416,778.57	(21,310.45)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	438,089.03	416,778.57	(21,310.45)

Авлага дансны үлдэгдэл 1.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулж ажилласантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6.6 сая төгрөгөөр өссөн нь 58.3 сая төгрөгийг бараа материал худалдан авч, 51.7 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26.8 сая төгрөгөөр буурсан нь 33.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө худалдан авалт хийж, үнэ төлбөргүй орлогоор 14.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 74.6 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 21.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 292.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 292.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 312.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 308.6 сая төгрөгийг зарцуулж, 4.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

2021 онд нэмэлт төсвийн гүйцэтгэлээр төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 58.9 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 58.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Шилэн дансны мэдээллийг хууль, журмын дагуу үнэн зөв мэдээлээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4 мэдээллийг ил тод байршуулаагүй, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаанаас бусад бүх мэдээг буруу мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд шилэн дансны 7 тэмдэглэл хугацаа хоцорсон, 35 мэдээлэл байршуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсарын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 1,332.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн, 1,279.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 51.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 1,241.6 сая төгрөгийн, үр дүнгийн тайланд 38.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

- ✓ 19.2 сая төгрөгийн түлш халаалт, гэрэл цахилгаан зэрэг ашиглалтын зардлыг бараа материалын дансаар дамжуулан бүртгэсэн;
- ✓ Хөрөнгө оруулалтаар баригдсан ЗДТГ-ын барилга, Аргалант багийн барилгын өртөг хүлээн зөвшөөрөх үндэслэл бүхий баримт бичиг байхгүй байхад даргын амаар 1,220.0 сая төгрөгөөр Үндсэн хөрөнгөд орлого авсан;
- ✓ 2.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгэсэн;
- ✓ 12 сарын бараа материалын тайланд үлдээгдлээр байгаа 7.0 сая төгрөгийн бараа материалыг зардлаар бүртгэсэн;
- ✓ Орон нутаг хөгжүүлэх сангаас санхүүжүүлсэн 30.0 сая төгрөгийн худалдан авалтыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж үр дүнгийн тайланд орлогыг давхардуулан хүлээн зөвшөөрсөн;
- ✓ Хувь хүнээс авах авлагад авсан 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрсөн;

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ УСНББОУС 12 Бараа материал, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгөд оршин байх, УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС 15 Толилуулга ба тодруулга стандартуудтай нийцээгүй, үнэн зөв байх, үнэлгээ ба хувиарлалт, иж бүрэн байх зэрэг батламж мэдээгдлүүдийг хангаагүй тул тул тайланг засварлуулсан.

4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ Няравын хувийн дансанд анхан шатны баримтгүй 0.96 сая төгрөг шилжүүлэн шууд зардлаар бүртгэсэн, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг гаргаагүй.
- ✓ Сумын Засаг даргад анхан шатны баримтгүй 0.35 сая төгрөгийн томилолт илүү олгосон.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3 заалтыг үндэслэн үндэслэлгүй олгосон төлбөрийг буцаан төвлөрүүлэх

4.2.3 Албан шаардлага

1.1. Илрүүлэлт:

- ✓ Өмнөх оны аудитаар шилэн дансны 7 мэдээлэл хугацаа хоцорсон, 35 мэдээлэл байршуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй тайлант онд зөрчлийг давтан алдаатай мэдээлэл байршуулсан байна.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.1.10 заалтыг үндэслэн албан шаардлага хүргүүллээ.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

- ✓ Түүвэрт хамрагдсан ажил гүйлгээнээс 51.6 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Түдэвтэй сумын Засаг даргын тамгын газар	10	1,332.7	6	1,279.8	2	1.3	1		1	51.6
	Дүн	10	1,332.7	6	1,279.8	2	1.3	1		1	51.6